БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлгий сумын хүүхдийн 18 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БӨА-2026/088/НА-СТА-ТШЗ**


Цахим хуудас: www.audit.mn

Баян-Өлгий аймаг

2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Утас:99422227 Цахим хаяг: @audit.gov.mn
Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 99932710 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
Аудитор: Р.Содномдаржаа
Утас: 99101563 Цахим хаяг: Uujimaudit@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт /Баталгаажсан хувийг оруулах

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

ӨЛГИЙ СУМЫН ХҮҮХДИЙН
18 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ С.ЛАГЫЛ ТАНАА

2026.02.24 № 105

танай ___________-ны № ___________-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын хүүхдийн 18 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлгий сумын хүүхдийн 18 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Өлгий сумын хүүхдийн 18 дугаар цэцэрлэг нь 2025 онд 1,289.8 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 1,277.4 сая төгрөг зарцуулж, 99 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

**Аудитын гол асуудал**

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

83100500б070

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.АЙГҮЛ

**Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,289,810,700.00** | **1,277,414,881.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,289,810,700.00** | **1,277,414,881.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,289,810,700.00** | **1,277,414,881.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **956,118,100.00** | **952,208,778.00** |
| 210101 | Үндсэн цалин | 661,049,000.00 | 662,918,100.00 |
| 210102 | Нэмэгдэл | 271,491,400.00 | 236,112,285.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 23,200,000.00 |
| 210104 | Урамшуулал | 21,807,600.00 | 29,978,393.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **119,012,700.00** | **112,424,500.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 80,764,000.00 | 76,454,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,562,200.00 | 8,995,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,781,100.00 | 4,498,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,781,100.00 | 4,498,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 19,124,300.00 | 17,977,100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **86,786,000.00** | **84,302,703.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,286,000.00 | 7,802,703.00 |
| 210302 | Түлш, халаалт | 20,000,000.00 | 20,000,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,500,000.00 | 1,500,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 55,000,000.00 | 55,000,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **94,431,000.00** | **94,431,000.00** |
| 210502 | Хоол, хүнс | 94,431,000.00 | 94,431,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,200,000.00** | **1,200,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 1,200,000.00 | 1,200,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **4,437,600.00** | **4,437,600.00** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,437,600.00 | 4,437,600.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **28,678,700.00** | **28,410,300.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 19,514,300.00 | 19,245,900.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,164,400.00 | 9,164,400.00 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,289,810,700.00** | **1,162,310,903.00** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,076,633,200.00** | **1,076,633,200.00** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,076,633,200.00 | 1,076,633,200.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **87,986,000.00** | **85,502,703.00** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 87,986,000.00 | 85,502,703.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **175,000.00** | **175,000.00** |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 175,000.00 | 175,000.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 124,100,000.0 | |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 138,447,833.62 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 23,343,855.62 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1.00** | **1.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **42.00** | **42.00** |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 19.00 | 19.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 22.00 | 22.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **42.00** | **42.00** |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 20.00 | 20.00 |
| 650007 | Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ) | 1.00 | 1.00 |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 1.00 | 1.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 20.00 | 20.00 |

**Гурав. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар 2.5 сая төгрөгийн алдаа[1] илэрч, аудитын явцад 2.5 сая төгрөгийн алдааг залруулсан.

Үүнд: Төсвийн гүйцэтгэлийн тайланд 2.5 сая төгрөгийн төвлөрүүлэг шилжүүлгийг тохируулга хийж цэвэрлээгүй байсан алдааг залруулав.

Энэ нь Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 12.1 сая төгрөгийн зөрчил[2] илэрч, 12.1 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

**Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой асуудал**

**<u>1.1 Илрүүлэлт:</u>**

Цэцэрлэгийн эрхлэгчийн 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/15 дугаар тушаалаар байгуулсан жилийн эцсийн тооллого хийх комисс тооллого хийхдээ 12.1 сая төгрөгийн түлш халаалт, бичиг хэргийн материал, шинээр орлогод авсан тавилга эд хогшлыг тооллого хийж тооллогын бүртгэлийг баримтжуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1-д ”жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”-гэсэн заалттай нийцэхгүй байна.

**<u>1.2 Өгсөн зөвлөмж:</u>**

Жилийн эцсийн тооллогыг иж бүрэн, үнэн зөв хийж тооллогын бүртгэлийг баримтжуулах талаар арга хэмжээ авч ажиллах, хяналтыг сайжруулах

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 09 дугаар сарын 01-ний өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэг шилжүүлгийг тохируулга хийж цэвэрлээгүй | 1 | 2,483.3 | 1 | 2,483.3 | | | 1 | 2,483.3 | | | | |
| Дүн | **1** | **2,483.3** | **1** | **2,483.3** | | | **1** | **2,483.3** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Жилийн эцсийн тооллогыг иж бүрэн, үнэн зөв хийж тооллогын бүртгэлийг баримтжуулах | 1 | 12,101.5 | | | | | 1 | 12,101.5 | | | | |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | **1** | **12,101.5** | | | | | **1** | **12,101.5** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| **Нийт дүн** | | | | | | | | |